



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/821

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмадын байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан цахим сургалт зохион байгуулах зардалд 300 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 300 000 төгрөг /Гурван зуун мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.7 дахь "Ахмадаа ачилъя" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 21-ний өдрийн
А/821 дүгээр захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Төрөл	Төсөв/төг/	Нийт төсөв /төг/
1	Гарын авлага хэвлэх зардал	50 ш	5000	250 000
2	Харилцаа холбооны зардал			50 000
Нийт дүн				300 000

-oOo-